



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 35

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 231 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны Зээлийн хөрөнгөөр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн МОН-3713” төслийн хүрээнд бий болсон нийт 1,939,828,243,31 (нэг тэрбум есөн зуун гучин есөн сая найман зуун хорин найман мянга хоёр зуун дөчин гурван төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн өртөгтэй цэвэрлэх байгууламжийг Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 8 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ




Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
35 дугаар тогтоолын хавсралт

Эрдэнэдалай сумын засаг даргын тамгын газрын цэвэрлэх байгууламжийн
үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/Д	Эд хөрөнгийн жагсаалт	Тайлбар, хүчин чадал, техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
Цэвэрлэх байгууламж						
1	Цэвэрлэх байгууламжийн барилга	Бетон цутгамал	ш	1		108,928,690.39
2	Биоцөөрөм, цэвэрлэгдсэн усны даралттай шугам	ф100 мм-ийн хуванцар хоолой, 2ш биоцөөрөм	ш	2	28,287,072	56,574,144
3	Хөвөгч лаг шахах насос	Q=5.2м3/ц H=5м	ш	1	3,650,000	3,650,000
4	Тунасан лаг шахах насос	Q=5.2м3/ц H=5м	ш	4	3,650,000	14,600,000
5	Агааржуулах насос		ш	2	2,450,000	4,900,000
6	Агааржуулалтын диффузер		ш	264	135,000	35,640,000
7	Хуванцар хоолой	25-250мм	м	386	16,965	6,548,490
8	Цэвэрлэх байгууламжийн дотор цахилгаан хангамж		иж бүрдэл	1	1,310,000	1,310,000
9	Цэвэрлэх байгууламжийн халдваргүйжүүлэх сан	Бетон цутгамал	ш	1	18,504,694	18,504,694
10	Өргөлтийн насос, хаалт арматур, шугам хоолой	Q=50м3/ц H=22м	ш	2	4,499,500	8,999,000
11	Цэвэрлэх байгууламжийн 10 КВ-ын ЦДАШ		иж бүрдэл	1	42,957,343	42,957,343
12	Цэвэрлэх байгууламжийн 0.4 КВ-ын ЦДАШ		иж бүрдэл	1	19,309,327	19,309,327



13	Цэвэрлэх байгууламжийн кабель шугам		иж бүрдэл	1	5,328,249	5,328,249
14	Цэвэрлэх байгууламжийн хаалттай дэд өртөө		иж бүрдэл	1	62,629,673	62,629,673
15	Цэвэрлэх байгууламжийн хашаа		ш	74	99.019	7,327,406
16	Гадна бохир усны шугам	Бохир усны хуванцар шугам хоолой ф100-200мм	м	2700	191,227	516,312,900
Цэвэр усны эх үүсвэр, усан сан, шугам сүлжээ						
17	Усан сангийн барилга		ш	1		80,844,976.92
18	Усан сан нөөцийн сав	50м3	ш	2	4,146,265	8,292,530
19	Халдваргүйжүүлэх төхөөрөмж		ш	1	1,570,000	1,570,000
20	Цэвэр усны насос		ш	4	2,525,000	10,100,000
21	Даралтат сав		ш	1	1,537,500	1,537,500
22	Дотор шугам хоолой, хаалт арматур		иж бүрдэл	1	2,364,000	2,364,000
23	Усан сангийн барилгын халаалт		иж бүрдэл	1	6,817,100	6,817,100
24	Усан сангийн барилгын агаар сэлгэлт		иж бүрдэл	1	1,951,200	1,951,200
25	Усан сангийн барилгын дотор цахилгаан хангамж, газардуулга		иж бүрдэл	1	5,700,000	5,700,000
26	Усан сангийн барилгын 0.4 КВ-ын кабель шугам, гадна гэрэлтүүлэг		иж бүрдэл	1	27,133,633	27,133,633
27	Усан сангийн барилгын хашаа		иж бүрдэл	1	4,678,800	4,678,800
28	Цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг, насос, шугам хоолой		ш	1	129,314,127	129,314,127



29	Цэвэр усны хуванцар цагираг шугам	ф100мм	м	2000	315,100	630,200,000
30	Цэвэр усны салбар шугам	ф20-50мм	м	480	175,103	84,049,440
31	Дулааны шугам	ф76-89мм	м	220	144,341	31,755,020
Нийт дүн						1,939,828,243.31 (нэг тэрбум есөн зуун гучин есөн сая найман зуун хорин найман мянга хоёр зуун дөчин гурван төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөг